



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2017/1



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn



ГАРЧИГ

- Ерөнхий тэмдэглэл
- Аргачлалын тайлбар.....
- I. Нийгмийн байдал.....
- II. Нийгмийн даатгал, халамж.....
- III. Эрүүл мэнд
- IV. Гэмт хэрэг
- V. Үнэ.....
- VI. Төсөв.....
- VII. Хөдөө аж ахуй
- VIII. Аж үйлдвэр
- IX. Цаг уур.....
- Хавсралт.....



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэл:

Сумдын нэр:

СҮ Сүмбэр

БТ Баянтал

ШГ Шивээговь

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XII зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй

0.0 Маш бага тоо+, - Зөрүү

- Гүйцэтгэл байхгүй* Дахин

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

• Хөдөлмөр:

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

• Нийгмийн даатгал, халамж:

✓ Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

✓ Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчийн нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.



- **Эрүүл мэнд**

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөнд тооцно.

✓ **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

✓ **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

- **Гэмт хэрэг:**

Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

✓ Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.

✓ Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.

✓ Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.

✓ Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.

✓ Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.

- **Үнэ**

Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ нь хэрэглэгчийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.



- **Төсөв санхүү:**

Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.

- **Хөдөө аж ахуй:**

Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын Тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.

- ✓ Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

- ✓ Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул, хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

- **Аж үйлдвэр:**

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

(2017 оны 1 дүгээр сарын байдлаар)



I. Нийгмийн байдал

I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн


Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 2017 оны 1 сард 327 байгаагийн 182 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 192 буюу 2.4 дахин, өмнөх сараас 89 буюу 37.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нэгдүгээр сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 44 ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх оны мөн үеэс 31 буюу 3.4 дахин нэмэгдсэн байна.

Тайлант оны 1-р сард Хөдөлмөр халамж, үйлчилгээний газраар 14 иргэн ажилд зуучлуулсны 8 буюу 57.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажилд зуучилсан иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2.8 дахин өслөө.

Зураг.1.1

Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, үүнээс эмэгтэй, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



Ажил хайгч иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 56, 25-34 насны 119, 35-44 насны 88, 45-54 насны 57, 55-59 насны 7 иргэн байна.


I.2 Ердийн хөдөлгөөн

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2017 оны 1 дүгээр сарын байдлаар 23 эх амаржиж, 24 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 5 буюу 17.6 хувиар, төрсөн хүүхдийн тоо 5 буюу 17.2 хувиар тус тус буурсан байна.

Нас баралт 7, бүртгүүлсэн гэр бүл 3, цуцалсан гэр бүл 4 байгаа нь өмнөх оны мөн үеэс нас баралт 1 буюу 16.7 хувиар, цуцалсан гэр бүл 3 буюу 4 дахин өсч, бүртгүүлсэн гэр бүл 2 буюу 40.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



Шинэ төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны 1 дүгээр сарын байдлаар 674.3 сая төгрөг, зарлага 618.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс орлого 337.7 сая төгрөгөөр буюу 2.0 дахин өсч, зарлага 36.8 сая төгрөгөөр буюу 5.6 хувиар буурлаа.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны 1 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 2 дахин өсөхөд ҮОМШӨ болон ЭМД сангийн орлого 4.2-10.8 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн зарлага 2017 оны 1 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс буурахад ЭМД-ын сангаас зарлага гараагүй нь голлон нөлөөлөв.

II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2017 оны 1 дүгээр сарын байдлаар 940 хүнд 74.8 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамж авагчдын тоо 5 хүн буюу 0.5 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж 10.8 сая төгрөг буюу 12.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2017 оны 1 дүгээр сарын байдлаар 682 хүн хамруулж 58.0 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 36 хүн буюу 5.0 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 3.5 сая төгрөг буюу 5.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2017 оны 1 дүгээр сарын байдлаар 258 хүн хамруулж 16.8 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 31 хүн буюу 13.7 хувиар нэмэгдэж, олгосон халамж үйлчилгээ хөнгөлөлт, тусламж 7.3 сая төгрөг буюу 30.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

II.3 Дундаж цалин

Аймгийн Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн 2017 оны 1 дүгээр сарын мэдээгээр 150 байгууллагын 3675 даатгуулагч иргэн, үүнээс 71 нь сайн дурын даатгуулагч байна. Нийт даатгуулагчдын цалин сан өссөн дүнгээр 3.5 тэрбум төгрөг байгаа бол сарын дундаж цалин сайн




дурын даатгуулагч ороогүй дүнгээр 973.9 мянган төгрөг байгаа нь зарим аж ахуйн нэгж байгууллагын 13 дахь сарын цалин болон үр дүнгийн урамшууллаас хамааралтай байна.

Ажиллагсдын цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 15 аж ахуйн нэгж, байгууллагын 956 ажилтны дундаж цалин нь 1407.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын 1427 ажилтны дундаж цалин нь 724.5 мянган төгрөг, 2 ХКомпанийн 594 ажилтны дундаж цалин нь 1214.0 мянган төгрөг, 69 ХХКомпанийн 525 ажилтны дундаж цалин нь 642.6 мянган төгрөг, бусад 11 байгууллагын 102 ажилтны дундаж цалин нь 468.7 мянган төгрөг боллоо.

Зураг II.1

Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2017 оны 1 дүгээр сарын байдлаар




III. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2017 оны 1 дүгээр сарын байдлаар 33 эх амаржиж 2016 оны мөн үетэй харьцуулахад 3 буюу 10.0 хувиар нэмэгдсэн байна. Амьд төрсөн хүүхэд 33 үүнээс 18 нь хүү, 15 нь охин байна. Өмнөх оны мөн үеэс амьд төрсөн хүүхэд 3 буюу 10.0 хувиар өссөн байна.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 1 дүгээр сарын байдлаар

Зураг III.1






0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, болон эхийн эндэгдэл бүртгэгдээгүй, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 1 бүртгэгдсэн байна.

Халдварт өвчин 1 дүгээр сарын байдлаар 16 буюу 10000 хүн амд 9.6 байгаа нь өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор нэмэгджээ.

Зураг III.2

Нас баралт, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



Он гарсаар давхардсан тоогоор 9914 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 250 буюу 2.5 хувиар буурч, 551 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 186 буюу 50.9 хувиар өссөн байна.

2017 оны 1 дүгээр сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 782, халдварт өвчин 16 бүртгэгдсэн байна.

Зураг III.3

Амьгүй төрөлт болон нялхасын эндэгдэл, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар




**IV. Гэмт хэрэг**

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2017 оны 1 дүгээр сарын байдлаар 22 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9 буюу 69.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг IV.1

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэргийн тоо өсөхөд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 6 буюу 3 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Илрээгүй гэмт хэрэг 6, гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 46 болсон нь илрээгүй гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 50.0 хувиар өсч, илрүүлэлтийн хувь 23.3 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.



Гэмт хэргийн улмаас 9 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс 4 буюу 30.8 хувиар буурсан байна.

Зураг IV.2

Гэмт хэргийн ангилал, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар




Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2017 оны 1 дүгээр сарын байдлаар 35 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 8.2 сая төг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирлын хэмжээ 28 сая төгрөгөөр буюу 4.0 дахин, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 2.5 сая төгрөг буюу 43.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2017 оны 1 дүгээр сарын байдлаар 48 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 29 буюу 37.7 хувиар буурсан байна.



Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо
жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2017 оны 1 дүгээр сард өмнөх сар буюу 2016 оны жилийн эцсээс 0.6 пунктээр, өмнөх оны мөн үеэс 5.6 пунктээр тус тус өссөн байна.

Хэрэглээний үнийн индекс, 2017 оны 1 дүгээр сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2017.I}{2016.I}$	$\frac{2017.I}{2016.XII}$
Ерөнхий индекс	105.6	100.6
Хүнсний бараа, ундаа, ус	109.6	100.1
Согтууруулах ундаа, тамхи	104.5	102.8
Хувцас, бөс бараа, гутал	109.6	102.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	107.1	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	99.7	100.1
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	104.3	100.7
Тээвэр	98.4	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.0	99.9
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	101.9	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	127.7	100.0
Бусад бараа, үйлчилгээ	101.7	100.0

**VI. Орон нутгийн төсөв**


2017 оны 1 дүгээр сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 1218.7 сая төгрөг, гүйцэтгэлээр 1070.5 сая төгрөг болж 87.8 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 1525.8 сая төгрөг, гүйцэтгэлээр 915.6 сая төгрөг болж 60.0 хувийн биелэлттэй байна.

2017 оны 1 дүгээр сарын байдлаар авлагын үлдэгдэл 26.4 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 30.8 сая төгрөг байна.

Зураг VI.1


Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн
1 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр

**VII. Мал аж ахуй**

Аймгийн хэмжээнд 2016 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 185558 хээлтэгч малын 92 буюу 0.05 хувь нь төллөсөн байна. Төл бойжилт 100.0 хувьтай байна. 2017 оны 1 дүгээр сарын байдлаар том малын зүй бус хорогдол гараагүй болно.


Зураг VIII.1

Төл бойжилт, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, толгойгоор





Хорогдсон хээлтэгч, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, толгойгоор




VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2017 оны 1 дүгээр сарын байдлаар 4895.0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 649.1 сая төгрөг буюу 11.7 хувиар буурсан ба үүнд уул уурхайн салбарын гаргалт нь 766.7 сая төг буюу 14.5 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 5222.6 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 275.3 сая төгрөг буюу 5.6 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нийт бүтээгдэхүүний 92.1 хувь буюу 4.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт борлуулалтын 94.6 хувь буюу 4.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Зураг VIII.1

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр





IX. Цаг агаарын мэдээ 1 дүгээр сарын байдлаар


Хур тунадас: Нийт 0.6 мм хур тунадас орсон.

Салхи: Ихэнх хугацаанд секундэд 3-8 метр, хамгийн их хурд нь 12 м/сек байсан.


Агаарын температур: Дунджаар -17.9 градус хүйтэн байсан бөгөөд хамгийн дулаан өдөр 25-ны өдөр буюу 5.5 градус хүйтэн, хамгийн хүйтэн өдөр 18-ны шөнө буюу 28.5 градус хүйтэн байлаа.

2017 оны 2 дугаар сарын ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Уур амьсгалын дунджаар агаарын температурын сарын дундаж 15-20 градус хүйтэн байна. Говьсүмбэр аймгийн нутгаар 1.5-3.5 мм цас орох төлөвтэй.



1 дүгээр зураг. 2 дугаар сарын агаарын температурын уур амьсгалын дундаж(°C)



3 дугаар зураг. 2 дугаар сард ордог хур тунадасны уур амьсгалын дундаж (мм)



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Нийгмийн статистик				
Амьд төрсөн хүүхэд	хүүхэд	30	33	110.0
Ажил хайгч иргэд, 1 дүгээр сарын эцэст	хүн	135	327	2.4 дахин
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	хүн	13	16	123.1
Бүртгэгдсэн гэмт хэрэг	хүн	13	22	169.2
Эдийн засгийн статистик				
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	1197.0	1070.5	89.4
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	708.6	915.6	129.2
Авлага	сая.төг	22.2	26.4	118.9
Өглөг	сая.төг	339.0	30.8	9.1
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	сая.төг	5544.1	4895.0	88.3
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	4947.3	5222.6	105.6
Төллөсөн хээлтэгч	толгой	9	92	10.2 дахин
Гарсан төл	толгой	9	92	10.2 дахин
Хорогдсон төл	толгой	0	0	*
Бойжсон төл	толгой	9	92	10.2 дахин
Том малын зүй бусын хорогдол	толгой	984	0	*



I.1 АЖЛЫН БАЙРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Ажил хайгч <u>иргэнийн тоо</u>	135	327	242.2
Үүнээс эмэгтэй	89	182	204.5
Ажлын байрны захиалга	13	44	338.5
Ажилд <u>жуучлагдсан иргэд</u>	5	14	280.0
Үүнээс эмэгтэй	1	8	800.0

I.2 ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Амаржсан эх	28	23	82.1
Төрсөн хүүхэд	29	24	82.8
Үрчлэгдсэн хүүхэд	0	0	*
Бүртгүүлсэн гэр бүл	5	3	60.0
Цуцалсан гэр бүл	1	4	400.0
Нас баралт	6	7	116.7

II.1 ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Сангийн төрөл	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	336.6	674.3	200.3
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	655.3	618.5	94.4



II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I		2017 I		$\frac{2017 I}{2016 I} \%$	
	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	945	86.6	940	74.8	99.5	86.4
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	718	61.5	682	58.0	95.0	94.3
Халамжийн тэтгэвэр	212	33.5	187	32.6	88.2	97.3
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	506	27.9	495	25.4	97.8	91.0
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	227	24.1	258	16.8	113.7	69.7
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	18	0.9	45	0.09	250.0	10.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	56	6.5	32	0.8	57.1	12.3
Нийгмийн халамжийн үйлчилгээ	153	16.7	179	15.5	117.0	92.8
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж					*	*
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж			2	0.4	*	*
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж					*	*



III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Төрсөн эх	30	33	110.0
Амьд төрсөн хүүхэд	30	33	110.0
Эрэгтэй	17	18	105.9
Эмэгтэй	13	15	115.4
Амьгүй төрөлт	0	0	*
Нийт нас баралт	7	9	128.6
Эмнэлгийн нас баралт	1	1	100.0
Хоног болоогүй нас баралт	0	1	*
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0	*
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	1	50.0
Эмчлэгдсэн өвчтөн	365	511	140.0
Амбулаторийн үзлэг	10164	9914	97.5
Халдварт өвчин	13	16	123.1



IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, төрлөөр

Үзүүлэлт	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	13	22	169.2
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг	7	10	142.9
Өмчлөх эрхийн эсрэг	3	9	300.0
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	1	1	100.0
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	0	2	*
Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	1	0	*
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	0	*
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	0	0	*
Бусад гэмт хэрэг	0	0	*
Гэмт хэрэгт холбогдогсод	12	15	125.0
15 хүртэлх насны	0	0	*
16-34 насны	10	8	80.0
35-с дээш	2	7	350.0
Боловсрол – Дээд	2	2	100.0
Боловсрол - Тусгай дунд	0	1	*
Боловсрол – Бүрэн дунд	6	7	116.7
Боловсрол – Бүрэн бус дунд	0	3	*
Боловсрол – Бага	3	1	33.3
Боловсролгүй	1	1	100.0
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	2	2	100.0
Ажилгүй иргэд үйлдсэн	8	5	62.5
Эмэгтэй хүн оролцсон	3	1	33.3
Хүүхэд оролцсон	0	0	*
Бүлгээр үйлдсэн	1	2	200.0
Согтуугаар үйлдсэн	5	7	140.0
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	13	22	169.2
Гудамж талбайд	7	4	57.1
ГХ-н улмаас нас барсан	0	0	*
ГХ-н улмаас гэмтсэн	13	9	69.2
Учирсан хохирол / сая.төг /	7	35	500.0
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	5.7	8.2	143.9



VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Нийт орлого	1197.0	1070.5	89.4
Татварын орлого	536.5	239.5	44.6
Орлогын албан татвар	379.6	159.6	42.0
Өмчийн татвар	28.0	6.6	23.6
Дотоодын бараа үйлчилгээний	-	267	*
Бусад	128.6	70.6	54.9
Татварын бус орлого	23.3	103.2	442.9
Хөрөнгийн орлого	-	-	*
Тусламжийн орлого	637.2	724.4	113.7
Төсөвт газрын өөрийн орлого	-	3.4	*

VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I	2017 I	$\frac{2016 X}{2016 I} \%$
Нийт зарлага	708.8	915.6	129.2
Урсгал зардал	705.8	900.6	127.6
Хөрөнгийн зардал	3.0	15.0	500.0
Төсөвт байгууллагын тоо	51	49	96.1
Төсөвт байгууллагын ажиллагсдын тоо	769	783	101.8

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Авлага	22.2	26.4	118.9
Өглөг	339.0	30.8	9.1



VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Төрөл	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Бүгд	9	92	1022.2
Ингэ	0	0	*
Гүү	0	0	*
Үнээ	4	25	625.0
Эм хонь	5	67	1340.0
Эм ямаа	0	0	*

VII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Сумд	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Дүн	9	92	1022.2
<u>Баянтал</u>	0	0	*
Сүмбэр	0	92	*
<u>Шивээговь</u>	9	0	*

VII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Төрөл	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Бүгд	9	92	1022.2
Ботго	0	0	*
Унага	0	0	*
Тугал	4	25	625.0
Хурга	5	67	1340.0
Ишиг	0	0	*

VII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Сумд	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Дүн	9	92	1022.2
<u>Баянтал</u>	0	0	*
Сүмбэр	0	92	*
<u>Шивээговь</u>	9	0	*



VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Төрөл	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Бүгд	984	0	*
Тэмээ	0	0	*
Адуу	26	0	*
Үхэр	53	0	*
Хонь	323	0	*
Ямаа	582	0	*

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Сумд	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Дүн	984	0	*
<u>Баянтал</u>	159	0	*
Сүмбэр	761	0	*
<u>Шивээговь</u>	64	0	*

VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Төрөл	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Бүгд	111	0	*
Тэмээ	0	0	*
Адуу	5	0	*
Үхэр	7	0	*
Хонь	23	0	*
Ямаа	76	0	*

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Сумд	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Дүн	111	0	0
<u>Баянтал</u>	60	0	0
Сүмбэр	45	0	0
<u>Шивээговь</u>	6	0	0



VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Нийт	5544.1	4895.0	88.3
Нүүрс	5277.3	4510.6	85.5
Дулаан	246.8	253.9	102.9
Цэвэр ус	14.0	18.8	134.3
Сувагжуулалт	5.9	8.5	143.6
Ноос	0.0	90.0	*
Бусад	0.0	13.2	*

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Нийт	4947.3	5222.6	105.6
Нүүрс	4680.5	4943.0	105.6
Дулаан, усан хангамж, ус ариутгал	266.7	269.3	101.0
Ноос	0.0		*
Бусад	0.0	10.3	*

VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлт	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I} \%$
Нүүрс борлуулалт /үнийн дүнгээр, сая.төг/	4680.5	4943.0	105.6
Нүүрс борлуулалт /биет хэмжээ, мян.тн/	194.5	205.0	105.4
Нүүрс гаргалт /үнийн дүнгээр, сая.төг/	5277.3	4510.6	85.5
Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.тн/	229.5	199.6	87.0
Ажиллагсад	595	567	95.3



Е-майл хаяг:

govisumber@nso.mn

Вэб хаяг:

govisumber.nso.mn

Мэдээллийн сангийн хаяг:

www.1212.mn

Утас:

70543222, 70543017